

Же́ди хуваарилалт

P

Оби-Ван Кеноби Камино гариг дээрх дайнд бэлтгэгдсэн хүчирхэг клон цэргүүдийн салаа байгааг Ёода мастерт амжилттай дамжуулжээ. Ёода мастер бүх гаригаас Же́ди дайчдыг дуудуулсан ба Т гаригаас дайчид иржээ. Бүх Же́ди цугласны дараа Ёода мастер нэг гаригаас ирсэн дайчдыг хүчнийх нь нийлбэр тэнцүү байхаар 2 хэсэгт хувааж нэг хэсгийг нь өөрөө, нөгөө хэсгийг нь Виндү мастераар удирдуулахаар болжээ. Гэвч зарим гаригаас ирсэн дайчдыг хүч тэнцүү 2 хэсэгт хуваах боломжгүй байв. Тиймээс Ёода мастер гариг бүрийн хувьд дайчдыг хүч тэнцүү 2 хэсэгт хуваах боломжтой эсэхийг мэдэх шаардлагатай болжээ.

Оролт: Эхний мөрөнд Же́ди дайчид ирсэн гаригийн тоо $T \leq 5$ байна.

Дараагийн Т мөрөнд уг гаригаас ирсэн дайчны тоог илэрхийлэх N болон дайчдын хүчийг тодорхойлох F_1, F_2, \dots, F_N эерэг тоонууд байрлана. i-р дайчны хүч F_i байна.

Гаралт: Гариг бүрийн хувьд нэг мөрөнд уг гаригаас ирсэн дайчдыг хүч тэнцүү 2 хэсэгт хуваах боломжтой бол "YES", үгүй бол "NO" (" " хашилтгүйгээр)хэвлэнэ.

Дэд бодлого 1: Тестийн 30%-д $N \leq 20$ ба дайчдын хүч $F_i \leq 10^{16}$ байна.

Дэд бодлого 2: Тестийн 40%-д $N \leq 35$ ба нэг гаригаас ирсэн дайчдын хүчний нийлбэр 50000-аас бага байна.

Дэд бодлого 3: Тестийн 30%-д $N \leq 35$ ба дайчдын хүч $F_i \leq 10^{16}$ байна.

Жишээ оролт:

2

3 1 2 3

5 1 2 3 4 5

Жишээ гаралт:

YES

NO

